



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2025/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Бадрал

Утас: 91983443

Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Төлбөрийн акт.....	9
3.1.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал	9
3.2 Албан шаардлага	9
3.2.1 Зардал данстай холбоотой асуудал	9
3.3 Зөвлөмж	9
3.3.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал	9
3.3.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал	10
3.3.3 Төрийн сангийн үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой.....	10
3.3.4 Авлагатай холбоотой асуудал.....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
БТСГ	Биеийн тамир спортын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.26 № 2/421
танай _____-ны № _____-т

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Б.АМАРТҮВШИН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Жаргалант сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 20,084.014.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 2,869,142.6 мянган төгрөг буюу 16.7 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,742,050.5	8,343,024.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,802,778.6	4,635,165.7
33	АВЛАГА	1,054,357.0	842,688.1
34	УРЬДЧИЛГАА	1,632,531.6	2,454,168.4
35	БАРАА МАТЕРИАЛ	252,383.2	411,002.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	18,790,186.0	18,265,108.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	18,790,186.0	18,265,108.6
39200	Биет хөрөнгө	18,267,742.6	17,760,195.4
39300	Биет бус хөрөнгө	522,443.4	504,913.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,532,236.6	26,608,133.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	86,380.7	50,499.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	86,380.7	50,499.4
41300	Өглөг	86,380.7	50,499.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,445,855.9	26,557,634.1
51	Засгийн газрын хувь оролцоо	24,445,855.9	26,557,634.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	11,107,384.2	11,107,384.2
51200	Хуримтлагдсан үр дүн	10,656,715.2	12,768,493.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,681,756.5	2,681,756.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,532,236.6	26,608,133.4

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	26,331,465.9	25,983,502.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	11,261,514.0	19,989,960.1
110	Орлогын албан татвар	10,401,597.8	19,041,633.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	10,925,241.3	19,678,581.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-523,643.5	-636,948.4
113	Хөрөнгийн албан татвар	331,229.3	514,144.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	528,686.9	434,182.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,187,825.1	3,094,765.5
120	Нийтлэг татварын бус орлого	3,187,825.1	3,094,765.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,882,126.8	2,898,777.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	23,249,794.8	23,880,041.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,421,557.6	22,661,845.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,251,040.5	13,740,878.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,119,269.2	2,012,750.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,201.0	249,196.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,541.3	4,325,501.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,822,178.5	2,298,328.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,590.6	165,532.8
2107	Томилолт, зочны зардал	6,608.6	3,920.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,695,311.9	1,114,242.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,332,339.4	3,571,406.7
212	ТАТААС	76,666.7	128,860.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,093,850.4	8,792,106.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	828,237.2	1,218,196.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,081,671.1	2,103,461.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,081,671.1	2,103,461.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,368,016.3	23,245,570.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	11,261,514.0	19,989,960.1
110	Орлогын албан татвар	10,401,597.8	19,041,633.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	10,925,241.3	19,678,581.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-523,643.5	-636,948.4
113	Хөрөнгийн албан татвар	331,229.3	514,144.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	528,686.9	434,182.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	63,273.0	78,346.3
1181	Газрын төлбөр	465,413.9	355,832.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	3.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226,975.6	372,559.0
120	Нийтлэг татварын бус орлого	226,975.6	372,559.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,879,526.8	2,883,051.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,150,585.9	17,173,105.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,150,585.9	17,173,105.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,979,735.8	8,250,981.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,129,397.9	1,653,301.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,025.3	201,630.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,232.1	4,113,665.8
2104	Хангамж, бараа материалын зардал	29,756.3	36,352.6
2105	Нормативт зардал	1,226.9	199.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,814.5	175,282.2
2107	Томилолт, зочны зардал	5,617.0	3,920.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,987,378.1	1,907,025.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	548,287.7	159,604.8
212	ТАТААС	76,666.7	128,860.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,094,183.4	8,793,263.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,217,430.4	6,072,464.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,810,432.7	4,131,304.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,810,432.7	4,131,304.2
2200	Дотоод эх үүсвэрээр	2,810,432.7	4,131,304.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,810,432.7	-4,131,304.2

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-108,682.9	-108,773.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	108,682.9	108,773.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,298,314.8	1,832,387.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	504,463.8	2,802,778.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,802,778.6	4,635,165.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	21,339,067.2	21,339,067.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	25,198.6	25,198.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,364,265.7	21,364,265.7
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-80.9	-80.9
9	Тайлант үеийн үр дүн	3,081,671.1	3,081,671.1
10	2023 оны 12-р сарын 31-нээр үлдэгдэл	24,445,855.9	24,445,855.9
11	2024 оны 1-р сарын 1-нээр үлдэгдэл	24,445,855.9	24,445,855.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,316.9	8,316.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,454,172.8	24,454,172.8
19	Тайлант үеийн үр дүн	2,103,461.3	2,103,461.3
20	2024 оны 12-р сарын 31-наар үлдэгдэл	26,557,634.1	26,557,634.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,163,670.0	12,316,245.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,628,579.4	8,362,695.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,459,935.8	8,200,359.1
210 1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,677,167.8	1,653,301.2
210 2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209,646.0	201,630.8
210 3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,204,244.9	4,113,665.8
210 4	Хангамж, бараа материалын зардал	36,894.9	33,190.6
210 5	Нормативт зардал	1,396.8	199.0
210 6	Эд хогшил, урсгал засварын зардал	187,522.5	175,282.2
210 7	Томилолт, зочны зардал	8,744.5	3,920.0
210 8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,908,477.1	1,896,619.9
210 9	Бараа үйлчилгээний бусад зардал	225,841.3	122,549.5
212	ТАТААС	135,000.0	128,860.0

212 2	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	135,000.0	128,860.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,643.6	33,476.3
213 2	Бусад урсгал шилжүүлэг	33,643.6	33,476.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,972,657.9	3,844,776.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	562,432.7	108,773.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,163,670.0	12,657,939.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,982,915.3	12,345,242.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,180,754.7	312,696.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	528,937.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	870,631.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	628,715.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,212.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,647.4
2104	Хангамж, бараа материалын зардал	3,360.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,368.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,918.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	291,565.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	283,145.6
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,419.6
22	ХӨРӨНГИЙН зардал	246,502.8
2200	Дотоод эх үүсвэрээр	246,502.8
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	628,715.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	628,715.4

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,531.0 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрснээс аудитын явцад 49,233.9 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Тухайн оны зээл, зээлийн хүүгийн авлагыг илүү тооцож тусгасан-15,451.7 мянган төгрөг,
- Засвар, тохижилт зэрэг ажлуудаас барьцаа суутгасныг тайланд өглөгөөр тусгаагүй-9,479.3 мянган төгрөг,
- Улсын комисс хүлээн аваагүй ажлыг зардлаар бүртгэсэн - /Бичигт багийн киоск худаг/ -24,302.8 мянган төгрөг,

ТТЗ-ийн болон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд болон илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхидауулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Залруулагдаагүй нийт 56,297.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 13,916.1 мянган төгрөгийн албан шаардлага бичиж, 41,781.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар “Баатар хайрхан багийн 7 дугаар сургуулийн доод талын сайжруулсан засмал зам”-ын санхүүжилтийг илүү тооцон, гүйцэтгэгч компанид хяналтын төсвийн 600,0 мянган төгрөгийг давхардуулан шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.7-д “Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана.”, Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 181 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНБД 81-94-12”-ийн 4.11-д “Захиалагчийн мэдлийн зардал нь газрыг ашиглах, эзэмших, өмчлөхтэй холбогдсон зардал, инженерийн хайгуул, зураг төслийн зардал, захиалагчийн хяналтын зардал, зөвлөх үйлчилгээ, тохируулга, зүгшрүүлэлт, магадлашгүй ажил зэргээс бүрдэнэ. Эдгээр зардал нь захиалагчийн мэдэлд байх бөгөөд гүйцэтгэл зардлыг үндэслэн холбогдох тооцоог хийнэ.” гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

3.2.1 Зардал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр шагайн харвааны тэмцээн, Алтай аймагт ажилласны зардал, Тайланд улсад хуралд оролцсоны зардал, зорилтот бүлгийн иргэдэд тусламж үзүүлсэн, шилдэг нийтлэлийн эмхэтгэлийн ном худалдан авсан зэрэг батлагдсан хөтөлбөрт нийцээгүй, санал авч дэмжигдээгүй үйл ажиллагаанд 13,916.1 мянган төгрөгийн санхүүжилтийг хөтөлбөр, арга хэмжээний зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.4-д “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” санхүүжүүлэхийг хориглоно гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн.

3.3 Зөвлөмж

3.3.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээний гэрээ байгуулан санхүүжилт олгохдоо 70:30 харьцаагаар олгож байгаа нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.3.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг энэ журамд зааснаар олгох бөгөөд цахим системд ангиллаас хамаарч бүрдүүлэх материалыг удирдлага болгож, санхүүжилтийг дараах байдлаар ангилна:”. 4.3.1.1-д “эхний санхүүжилт;”, 4.3.1.2-д “дундын буюу явцын санхүүжилт”, 4.3.1.3-д “эцсийн буюу бүрэн санхүүжилт”, 4.8.13-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журамд заасны дагуу урьдчилгаа санхүүжилтийг 30 хувиас хэтрүүлэхгүй байх.

3.3.2 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний эцсийн санхүүжилт олгохдоо барьцаа суутгаагүй нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.2.2.5-д “Төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;”, 4.2.2.6-д “Чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг гүйцэтгэл тус бүрээс, эсхүл эцсийн буюу бүрэн санхүүжилтээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43.6-д заасны дагуу суутган барьцаа хөрөнгийн дансанд байршуулах асуудлыг тухайн төсөл, арга хэмжээний гэрээний тусгай нөхцөлд тусгасан байх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”

Өгсөн зөвлөмж: Хэрэгжиж дууссан ажлаас журамд заасны дагуу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацаанд барьцаа байршуулах, гэрээнд тусгах.

3.3.3 Төрийн сангийн үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлаас тавилга эд хогшил, үндсэн хөрөнгө худалдан авч зардлын эдийн засгийн ангилал зөрчиж байгаа нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-т “төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн хяналтыг сайжруулах, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийхгүй байх.

3.3.4 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өндөр насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Тухайн оны зээл, зээлийн хүүгийн авлагыг илүү тооцож тусгасан	1	15,451.7			1	15,451.7	1	15,451.7				
Орон нутгийн хөгжлийн сан	Засвар, тохижилт зэрэг ажлуудаас барьцаа суутгасныг тайланд өглөгөөр тусгаагүй	1	9,479.3	1	9,479.4			1	9,479.3				
Орон нутгийн хөгжлийн сан	Улсын комисс хүлээн аваагүй ажлыг зардлаар бүртгэсэн - /Бичигт багийн киоск худаг/	1	24,302.8			1	24,302.8	1	24,302.8				
	ДҮН	3	49,233.9	1	9,479.4	2	39,754.5	3	49,233.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээний гэрээ байгуулан санхүүжилт олгохдоо ЗГ-ын тогтоол баримтлахгүй 70:30 харьцаагаар олгосон .	1	-						1	-		
	Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний эцсийн санхүүжилт олгохдоо барьцаа суутгаагүй.	1	10,471.1						1	10,471.1		
	Өндөр насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	29,500.0						1	29,500.0		
	Шагайн харвааны тэмцээн, Алтай аймагт ажилласны зардал, Тайланд улсад хуралд оролцсоны зардал, зорилтот бүлгийн иргэдэд тусламж үзүүлсэн, шилдэг нийтлэлийн	1	13,916.1				1	13,916.1				

	эмхэтгэлийн ном худалдан авсан зэрэг батлагдсан хөтөлбөрт нийцээгүй, санал авч дэмжигдээгүй үйл ажиллагааг хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэн зарцуулсан.									
	Баатар хайрхан багийн 7 дугаар сургуулийн доод талын сайжруулсан засмал замын санхүүжилтийг илүү тооцон гүйцэтгэгч компанид төсвийн мөнгийг давхардуулан шилжүүлсэн.	1	600.0	1	600.0					
Төвлөрүүлэн захирагч	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлаас тавилга эд хогшил, үндсэн хөрөнгө худалдан авч зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	1,809.9					1	1,809.9	
	ДҮН	6	56,297.1	1	600.0	1	13,916.1	4	41,781.0	

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			